

ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
БҮХИЙ ТАЛБАЙД ГҮЙЦЭТГЭСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЖИЛИЙН ТАЙЛАН  
ХҮЛЭЭН АВАХ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ДООД ХЭМЖЭЭГ ТООЦОХ”  
ДОТООД ЗААВАР

Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.4-д заасны дагуу Цөмийн материалын хэлтсийн тайлан хүлээж авах мэргэжилтэн нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн боловсруулсан жил бүрийн хайгуулын ажлын тайланг дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор албан тоотоор хүлээн авна.

Тайланг Цөмийн материалын хэлтсийн мэргэжилтэн хүлээн авахдаа энэ зааврын дагуу хайгуулын ажлын тайланд дүгнэлт хийх бөгөөд дүгнэлт нь геологи-хайгуулын ажлын болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулах гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Нэг. Геологи-хайгуулын ажлын хэсэгт дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.1 Хайгуулын ажлын жилийн тайланг тусгай зөвшөөрлийн талбай тус бүрээр монгол хэл дээр албан бичиг, төлөвлөгөө, тайлан, гэрээ боловсруулах стандарт / Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс баталсан “Зохион байгуулалт-захирамжлалын баримт бичиг”/-ын дагуу бичсэн байна.

1.2. Хайгуулын ажлын жилийн тайлан нь Оршил, Хайгуулын талбайн болон объектын геологийн тогтоц, Эрэл, хайгуулын ажил гүйцэтгэсэн аргачлал, Эрэл, хайгуулын ажлын үр дүн, Байгаль орчны нөхөн сэргээлт, Дүгнэлт гэсэн бүлгүүд бүхий тайлбар бичиг, эдгээртэй холбогдох Хавсралт зургуудаас бүрдэнэ.

*Оршил бүлэгт* талбайн байршил (засаг захиргаа, газар зүй, солбицол), физик-газар зүйн онцлог, дэд бүтэц, хайгуулын ажлын үе, шат, хайгуулын анги, нэгжийн бүрэлдэхүүн, техник хангамж, ажил гүйцэтгэсэн хугацааны талаарх ерөнхий мэдээллийг тодорхой тусгасан байна.

*Хайгуулын талбайн болон объектын геологийн тогтоц* бүлэгт тусгай зөвшөөрлийн талбай, хайгуулын үе шатын ажил гүйцэтгэсэн объектын хэмжээн дэх хурдас чулуулгийн тархалт, шинж, онцлог, геологийн биетүүдийн тогтцын талаар товч ойлгомжтой бичих бөгөөд харин эрэл, хайгуулын ажил хийж буй тухайн ашигт малтмалын хувьд эрлийн шалгуур (стратиграфи, литологи, магматизм, структур, геоморфологи г.м.,) шинж тэмдэг (шууд ба шууд бус) болж буй хурдас чулуулаг, биетүүдийн тогтоцын талаар өмнөх судалгааны болон өөрсдийн гүйцэтгэсэн ажлын үр дүнд тулгуурлан дэлгэрэнгүй бичиж оруулна. Хурдас чулуулгийн стратиграфийн ангиллын бичлэгийг Монголын литостратиграфийн кодексын дагуу хийсэн байна.

*Эрэл, хайгуулын ажил гүйцэтгэсэн аргачлал* бүлэгт тусгай зөвшөөрлийн талбайд өмнө нь ялгасан ашигт малтмалын эрлийн хэсэг, талбай, илрэл болон судалгааны ажлын үр дүн, бусад эрлийн шинж тэмдгүүдийн талаар товч, ойлгомжтой бичиж, түүнд үндэслэн боловсруулсан арга аргачлалын дагуу гүйцэтгэсэн эрэл, хайгуулын ажлын үе шат (хээрийн судалгааны ажлын

нарийвчлал, геофизик, геохими, уул өрөмдлөгийн ажлын тор, лабораторийн шинжилгээ, суурин боловсруулалт гэх мэт.) тэдгээрийн төрөл, хэмжээ, сонгосон аргуудын үндэслэл, гүйцэтгэсэн дарааллын талаар тодорхой бичнэ. Тусгай зөвшөөрлийн талбайд тухайн жилд гүйцэтгэсэн ажлын төрлүүд, тэдгээрийн хэмжээ, нэгжийн өртөг, нийт зардлыг Маягт-1-ийн дагуу нэгтгэн гаргаж тайланд хавсаргана.

*Эрэл, хайгуулын ажлын үр дүн бүлэгт* тухайн талбайд гүйцэтгэсэн эрэл, хайгуулын ажлын үр дүнд ялгасан хайгуулын талбай, хэсэгт тогтоогдсон:

Хүдрийн бүс, дүүрэг, зангилаа, илрэл, эрдэсжсэн цэг, биет, эрдсийн болон элементийн сарнилын хүрээ, хянаж буй структур, хувирлын шинж онцлог, эрдсийн болон элементийн эвшил,

Геофизикийн аномали,

Хүдэржилтийн төрөл, гарал үүсэл, тархалтын хэлбэр, биетийн хэмжээ, ашигт элемент, нэгдлүүд урьдчилсан байдлаар тооцож буй нөөц-баялгийн үнэлгээ, түүнийг тооцсон аргачлал,

Газрын гадаргуун болон газрын гүний усны тархалт,

Геоэкологийн судалгаа гэх мэт мэдээллүүдийг тодорхой тусгасан байна.

*Байгаль орчны нөхөн сэргээлт бүлэгт* тухайн хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээнд байгаль орчны нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө, түүний хэрэгжилт, биелэлтийн талаархи мэдээллийг тодорхой тусгасан байна. Мөн түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажил гүйцэтгэсэн болон байгаль орчны нөхөн сэргээлт хийсэн тухай мэдээг Маягт 7-оор гаргах бөгөөд сум, орон нутгийн байгаль орчны байцаагчийн дүгнэлтийн эх хувь эсвэл нотариатаар батлуулсан хувийг тайланд хавсаргасан байна.

Гэрээгээр гүйцэтгүүлсэн геологи, геофизик, геохими, гидрогеологи, өрөмдлөг, уулын ажил, топогеодези, лаборатори гэх мэт ажлуудын үр дүнг тусгахдаа тэдгээрийг гүйцэтгэсэн тухайн аж ахуйн нэгжийн албан ёсны шаардлагатай баримт бичиг /гэрээ, хэлцэл, лабораторийн захиалгын хуудас, шинжилгээний үр дүн, хилээр дээж нэвтрүүлсэн албан бичиг, гаалийн мэдүүлэг гэх мэт /-ийг хавсаргана.

Тухайн жилд хийгдсэн геологи, хайгуулын ажлыг байр зүйн солбицол /градус, минут, секунд/ -оор баталгаажуулсан байна. Үүнд: Геологийн зураг, ашигт малтмалын зураг, геологийн дээжлэлт хийсэн байршлыг тусгасан баримт материалын зураг, уул, өрөмдлөгийн ажил, геофизикийн болон топогеодезийн ажил гэх мэт.

*Дүгнэлт бүлэгт* Тусгай зөвшөөрлийн талбайд явуулсан эрэл, хайгуулын ажлын аргачлал, гүйцэтгэсэн ажлын үр дүнд дүгнэлт хийж, үүнийхээ үндсэн дээр талбайн хэтийн төлвийн талаар нэгдсэн үнэлгээ өгч, цаашид явуулах эрэл, хайгуулын ажлын чиглэлийг тусгаж өгсөн байна.

*Хавсралт зургууд:* Хайгуулын ажлын тайланд Баримт материалын зураг, Геологи-ашигт малтмалын зураг, Геохими, Шлих, Геофизикийн судалгаа (эдгээр ажлууд хийгдсэн тохиолдолд)-ны баримтжилт болон үр дүнгийн зургууд, геологийн болон геофизикийн зүсэлтүүд, цооногийн болон уулын ажил (суваг, шурф, траншей г.м.,)-ын бичиглэлүүд гэх мэт зайлшгүй шаардлагатай зураг, бүдүүвчүүдийг зохиож хавсаргана. Зургийн масштабыг эрэл, хайгуулын ажил гүйцэтгэсэн талбайн хэмжээ, рельефийн байдал, судалгааны ажлын үе шатаас хамааруулан оновчтой байдлаар сонгосон байна. Зургийн ачааллаас хамааран

зарим зургуудыг нэгтгэн зохиож болно. Зургийн өнгө, тэмдэглэгээ, таних тэмдгүүд бусад холбогдох зүйлүүд нь геологийн зурагт тавьдаг шаардлагыг хангасан байна. Мөн тайлангийн бичвэрт шаардлагатай фото болон бүдүүвч зураг, диаграммуудыг оруулж болно. Тайлангийн бүх зургууд нь байр зүйн солбицлоор баталгаажуулагдсан байна.

Тусгай зөвшөөрлийн талбай дотор эрлийн хэсэг, талбайг тусад нь ялгаж нарийвчилсан ажил хийсэн бол тэдгээртэй холбогдох зургуудыг тус тусад нь зохиож оруулна. Баримт материалын зургийг байр зүйн зургийн суурин дээр гүйцэтгэсэн ажлыг жил тус бүрээр өнгөөр ялган үзүүлсэн байна.

Лабораторийн шинжилгээний үр дүн, сорьцлолт, геофизикийн судалгааны үзүүлэлт гэх мэт олон тооны тоон үр дүнгүүдийг тусад нь хавтаслаж, Хавсралт-боть байдлаар ирүүлж болно.

Хоёр. Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг Цөмийн материалын хэлтсээс баталгаажуулахдаа дор дурдсан заавар, стандартыг баримтлана. Үүнд:

2.1. Хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дах хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн геологи хайгуулын ажлын жилийн тайлан болон санхүүгийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулна.

2.2. Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг санхүүгийн тайлан тэнцлээр баталгаажуулах хугацаа дараа оны эхний хагас жилээр дуусгавар болно. Энэ хугацаанд тайлангаа баталгаажуулаагүй бол /хуулийн этгээдийг/ тайлангаа ирүүлээгүйтэй адилтган үзэх болно.

2.3. Геологи, хайгуулын ажлын зардалд Маягт 1-д харуулсан бэлтгэл ажил, геологийн зураглал, зураглал-эрлийн маршрут, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгаа, уул өрмийн ажил, сорьцлолт, лабораторийн шинжилгээ, тээвэр, суурин боловсруулалт болон бусад хайгуулын бүх шатны ажлын зардлууд хамаарагдана.

2.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын зардлыг тайлагнахдаа санхүүгийн тайлан тэнцэл, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн олон улсын стандарт-6 /цаашид СТОУС-6 гэнэ/, аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого зохицуулалтын баримт бичгийг ашиглана. СТОУС-6-д зааснаар хайгуулын ажлын зардлыг хайгуулын тусгай зөвшөөрөл тус бүрээр нь хуримтлуулан бүртгэж капиталжсан зардлаар тайлагнана.

2.5. Биет бус хөрөнгийн дансанд хайгуулын тусгай зөвшөөрөл нь СТОУС-6, Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн /цаашид ААНБОАТ гэнэ/ 13-р зүйлийн 13.6-д “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн элэгдэл хорогдлын шимтгэл тооцох үнийг эдгээр тусгай зөвшөөрлийг эзэмших, шилжүүлэн авахтай холбогдон төлсөн үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн төлбөр, худалдан авсан үнийн дүнгээр тодорхойлно” гэж заасны дагуу тайлан тэнцэлд цэвэр дүнгээр тайлагнана. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд ААНБОАТ-ын хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар хүчин төгөлдөр байх хугацаанд нь элэгдэл тооцож үнийн дүнг хорогдуулна.

2.6. Хайгуулын ажлыг бусдаар гэрээгээр гүйцэтгүүлсэн тохиолдолд холбогдох нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг хийсэн байна.

2.7. Тухайн хайгуулын зөвшөөрөл бүхий талбайд хөрөнгө оруулалт хийгдсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн санхүүгийн тайлан тэнцэлд хөрөнгө оруулалтын хэмжээг тусгасан байна.

2.8. Санхүүгийн тайлан тэнцлийг санхүүгийн хэлтэс болон татварын хэлтсээр хянуулж баталгаажуулсан байна.

2.9. Санхүүгийн тайланг аудиторроор баталгаажуулсан бол аудиторын дүгнэлтийг хавсаргана.

2.10. Тухайн жилд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын хэмжээгээр зардлын хэмжээг тодорхойлно. Энэ хэмжээ нь хуулиар тогтоосон зардлын доод хэмжээнээс багагүй байна.

2.11. Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх хэсгээс 33.1.3 дах хэсэгт заасны дагуу хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянахад ам.долларын ханшийг хайгуулын ажил хийсэн тухайн оны Монгол банкны ам.долларын дундаж ханшаар тооцно.

Гурав. Бусад зүйл

3.1. Хайгуулын ажлын жилийн тайланд Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон түүний хавсралтуудын хуулбарыг хавсарган ирүүлнэ.

3.2. Тухайн жилд тусгай зөвшөөрлийн талбайд ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хуримтлал, биетийг илрүүлж, хайгуулын ажил хийн ашигт малтмалын баттай, бодитой нөөц тогтоосон тохиолдолд эцсийн үр дүнгийн тайланг Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн агуулга, түүнд тавих шаардлагын дагуу боловсруулна.

3.3. Тусгай зөвшөөрлийн талбайд тухайн жилд нөөцийн тайлан бичсэн болон бичигдэж байгаа тохиолдолд жилийн тайланг ирүүлэхдээ хайгуулын ажлын үр дүн, гүйцэтгэсэн ажил, зардлын мэдээллийг энэхүү зааврын дагуу боловсруулж ирүүлнэ.

3.4. Жилийн үр дүнгийн тайланг хянуулж, хүлээлгэж өгөх үед зарим шаардлагатай анхдагч материал, санхүүгийн баримтыг шаардсан тохиолдолд саадгүйгээр авчирч хянуулна. Шаардсан мэдээ, мэдээлэл нь цаасан болон тоон хэлбэр (CD хуурцаг) -ээр бичигдсэн байж болно.

3.5. Тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн эрэл, хайгуулын ажлын талаарх зарим мэдээллүүдийг дараах маягтуудын дагуу гаргаж тайланд хавсаргасан байна.

Үүнд:

- Гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил /хэмжээ, зардал/, (Маягт-1)
- Гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын зардлын задаргаа/, (Маягт-2)
- Өрөмдлөгийн болон уулын ажлын мэдээлэл, (Маягт-3)
- Дээж, сорьцын лабораторийн шинжилгээний мэдээлэл, (Маягт-4)
- Талбайд тогтоосон ашигт малтмалын мэдээлэл, (Маягт-5)
- Бүрдүүлсэн анхдагч материалын жагсаалт, (Маягт-6)

- Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын мэдээ, (*Маягт-7*)
- Ажиллах хүчний мэдээ, (*Маягт-8*)
- Хөрөнгө оруулалтын мэдээ, (*Маягт-9*)

3.6. Хэрвээ тусгай зөвшөөрлийн талбайд тухайн жилд гүйцэтгэсэн эрэл, хайгуулын хээрийн ажилтай холбоотойгоор ямар нэгэн осол гарсан бол тэр талаарх мэдээллийг тайланд тодорхой бичсэн байна.

3.7. Тайланг зохиоход ашигласан эх материалын нэрсийг зохих дарааллын дагуу жагсааж хавсаргана.

3.8. Тайлангийн нүүр хуудсыг *Хавсралт-1*-д үзүүлсэн маягаар үйлдсэн байна.

3.9. Тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайланг боловсруулсан геологийн болон санхүүгийн холбогдох ажилтнууд нь гарын үсгээ зурж, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага хянаж, баталгаажуулсан байна.

3.10. Тусгай зөвшөөрлийн талбайд тухайн жилд хийсэн бүх төрлийн эрэл, хайгуулын ажлын үр дүнг тайлангийн зохих бүлгүүдэд бүрэн тусгасан байна. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг тайланд дутуу буюу огт тусгаагүй тохиолдолд тайланг хүлээж авахгүй.

3.11. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлж байгаа тайлан нь энэ заавар шаардлагыг хангахгүй бол албан тоотоор тухайн аж ахуйн нэгжид буцаана.

3.12. Тайланд холбогдох мэргэжилтнүүд гарын үсэг зурж баталгаажуулсаны дараа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тайланг төрийн захиргааны байгууллагад хүргүүлснээр тухайн жилийн тайланг хүлээн авсанд тооцно.

3.13. Хайгуулын ажлын тайланд тусгагдсан мэдээллүүдийн үнэн бодит байдлыг тухайн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хариуцана.

3.14. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн геологи, хайгуулын ажлын тайлангийн арга аргачлал, гүйцэтгэсэн ажлын хэмжээ болон түүнд зарцуулагдаж хянагдсан зардалд дахин задаргаа болон дүн шинжилгээнд тайлан хүлээн авч байгаа мэргэжилтнүүд хяналт тавина.

3.15. Эрдсийн баялгийн үнэлгээ бүхий зураглал, эрэл хайгуулын ажлын тайланг мэргэшсэн геологич, харин ордын нөөцийн тооцоолол бүхий хайгуулын ажлын үр дүнгийн тайланг тухайн ашигт малтмалын чиглэлээр зөвлөх эрхтэй геологич толгойлон боловсруулна.

3.16. Хэрэв энэ зааварт заасан шаардлагыг биелүүлээгүй хайгуулын ажлын тайланг хүлээн авсан бол тухайн тайланг хүлээн авсан Цөмийн материалын хэлтсийн мэргэжилтэн нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

.....  
(Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр )

.....  
(Тайлан зохиогчийн нэр )

..... АЙМГИЙН ..... СУМЫН НУТАГ ДАХЬ  
..... ТАЛБАЙД ..... ОНД буюу ..... ДЭХ ЖИЛД  
ГҮЙЦЭТГЭСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тусгай зөвшөөрлийн дугаар:.....

Ашигт малтмалын төрөл:.....

Судалгааны үе, шат:.....

Хянаж, хүлээн авсан:

.....

.....оны .....сарын..... өдөр  
ЦЭГ-ын ЦМХ-ийн мэргэжилтэн

.....

.....оны .....сарын..... өдөр

..... ОН

.....ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙД  
 .....ОНД буюу .....ДЭХ ЖИЛД ГҮЙЦЭТГЭСЭН ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН АЖИЛ  
 ( төлөвлөгөөний биелэлт )

Д/ д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Төлөвлөсөн		Гүйцэтгэл		
			Ажлын хэмжээ	Зардал , ₮	Нэгжийн өртөг	Ажлын хэмжээ	Зардал , ₮
1	Бэлтгэл ажил						
	-Төлөвлөгөө зохиох	х/ө					
	- Агаар, сансрын зургийн тайлал	кв.км					
	-						
2	Талбайн зураглал	кв.км					
3	Эрлийн маршрут	т.км					
4	Талбайн сорьцлолт						
	Геохими:	сорьц					
	-						
	Шлихийн сорьцлолт	сорьц					
5	Геофизикийн ажил:						
	-	Физ.цэг					
	-						
6	Уулын ажил:						
	- суваг малталт	куб.м					
	- шурф нэвтрэлт	т.м					
	-						
	-	куб.м					
7	Өрөмдлөг:						
	-Баганат	т.м					
	-Цохилтот	т.м					
	-						
8	Сорьцлолт						
	-	ш					
	-	ш					
9	Лабораторийн ажил:						
	-						
	-						
10	Тээвэр:						
11	Топогеодезийн ажил						
12	Суурин боловсруулалт	х/ө					
	-						
13	БО-ны.нөх.сэрг.зардал						
14	гэх мэт бусад						
	<b>Зардлын нийт дүн</b>						
	<b>1 га талбайд ногдох зардал</b>						

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: .....ХХК -ийн

Тамга

Захирал .....

Геологич.....

Санхүүч:.....

.... тоот хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 20 онд буюу дэх жилд гүйцэтгэсэн ГХА-ын зардлын задаргаа

Мян/төг

1	Ажлын төрөл	Цалин	ИДШимтгэл	Материалын зардал	Бичиг хэрэг	Холбоо	Томилолт	Ашиглалтын зардал	Түлш шатахуун	Үндсэн хөрөнгийн элэгдэл	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	Тээвэр		Засварын зардал	БОНС-ын зардал	Бусад	Зардлын нийт дүн
												Хүн	Ачаа				
1	Бэлтгэл ажил																
	Төлөвлөгөө зохиох																
	Сансрын АСФЗ-ын тайлал																
2	Геологийн зураглал																
3	Эрлийн маршрут																
4	Талбайн сорьцлолт																
5	Геохимийн судалгаа																
6	Геофизикийн судалгаа																
7	Гидрогеологийн ажил																
8	Геоморфологийн ажил																
9	Топогеодезийн ажил																
10	Уулын ажил																
	Копуш нэвтрэлт																
	Шурф нэвтрэлт																
	Булалт																
11	Өрөмдлөг																
	Баганат																
	Цохилтот																
12	Сорьцлолт /Шурфын шлих/																
13	Лабораторийн ажил																
14	Суурин боловсруулалт																
	Нийт Дүн																

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: ”

“

ХХК-ийн Захирал  
Тамга

Нягтлан бодогч

Хүлээн авсан:

Мэргэжилтэн:.....



.....хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд.....онд гүйцэтгэсэн  
Өрөмдлөгийн болон Уулын ажлын мэдээлэл

<i>Цооногийн мэдээлэл</i>							
д/д	Цооногийн дугаар	Байршил /солбицол /	Цооног-ийн гүн,м	Керний гарц, хувь	Авсан дээж, сорьцын төрөл, тоо	Эрлийн хэсэг, илрэлийн нэр	
	нийт						
<i>Суваг малталт</i>							
д/д	Сувгийн дугаар	Байршил /солбицол /	Сувгийн эзлэхүүн, м3	Хэмжээ		Авсан дээж, сорьцын төрөл, тоо	Эрлийн хэсэг, илрэлийн нэр
				Урт, м	Гүн, м		
	нийт						
<i>Шурф нэвтрэлт</i>							
д/д	Шурфийн дугаар	Байршил /солбицол /	Шурфын гүн, м	Сорьцлолтын ахиц	Авсан дээж, сорьцын тоо	Эрлийн хэсэг, илрэлийн нэр	
	нийт						

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: ..... ХХК-ийн  
Тамга Захирал .....  
Геологич.....



.....хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд .....онд бүрдүүлсэн  
Анхдагч материалын жагсаалт

д/д	Баримтын нэр, дугаар	Тоо, ширхэг	Баримт дахь ажлын хэмжээ	Баримт бүрдүүлсэн геологчийн нэр	Баримт хадгалж буй газар	Тайлбар

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: .....ХХК-ийн  
Тамга Захирал .....  
Геологич.....

.....хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд .....онд хийсэн  
Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын мэдээ

д/д	Уулын ажил /цооног/-ын дугаар	Байршил /солби-Цол/	Ажлын хэмжээ м3 /т.м/	Нээсэн огноо	Хаасан огноо	Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ	Зардал /мян.төг/
<b>Суваг:</b>							
<b>Шурф:</b>							
<b>Цооног:</b>							
<b>Бусад ажил</b>							
<b>Дүн</b>							

Мэдээ гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигч: .....ХХК-ийн  
Тамга Захирал .....

Мэдээг хүлээн зөвшөөрсөн: ..... аймгийн ..... сумын  
байгаль орчны улсын байцаагч ..... овогтой .....  
Тамга

.....хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн .....оны  
Ажиллах хүчний мэдээ

д/д		Захиргааны ажилтан		Инженер, техникийн ажилтан		Ажилчид	
		тоо	х/ө	тоо	х/ө	тоо	х/ө
	Нийт:						
	Үүнээс:						
	дотоод						
	гадаад						

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: .....ХХК-ийн

Тамга

Захирал .....

Хүний нөөцийн мэргэжилтэн.....

.....хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн .....оны  
Хөрөнгө оруулалтын мэдээ

д.д		Гадаадын хөрөнгө оруулагч	Дотоодын хөрөнгө оруулагч	Тайлбар
1.	Хөрөнгө оруулагчийн нэр, хаяг, иргэний харьяалал			
2.	Хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ			
3.	Хөрөнгө оруулсан үе шат, хугацаа.			
4.	Бусад			
5.				

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: .....ХХК-ийн

Тамга

Захирал .....

Хөрөнгө оруулагч:..... гарын үсэг /.....нэр.....овог/

..... аж ахуйн нэгжийн нэр

Тамга